



**"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 04 дүгээр  
сарын 01-ний өдөр

№ 05


Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
цахим хэлбэрээр хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3 заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 20 өдрийн 13 тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 5 өдрийн "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах тухай" зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийх болсонтой холбоотой зарыг Монголын Хөрөнгийн Бирж болон компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, телевизээр дамжуулан нийтэд мэдээлсүгэй.
3. "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг Хавсралт 01-ээр баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, зохион байгуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллахыг Хурлын дарга /С.Сайнбат/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



С.ХОСБАЯР